

Living the Lotus 11

Buddhism in Everyday Life

2025
VOL. 242

Гадаад салбарын гишүүд Ничирэн гэгээнтнийг
дурсах “Оэшики” баярт оролцов



Living the Lotus
Vol. 242 (2025.11)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, ОУХ
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд) хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Найрал хөгжим хамтын хүчээр бий болдог-1 “Хагарал ба эв нэгдэл”

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Бидэнд өөр очих газар үгүй

Энэ сард Үүсгэн байгуулагчийн төрсөн өдрийн ёслол тохионо. Тэрбээр амьдралынхаа турш хүн төрөлхтний эв нэгдэл, дэлхийн энх тайвны төлөө залбирч, надтай адил 88 настай байхдаа “Амьд яваа минь өөрөө бусдад өглөг буян болох тийм амьдралыг туулах юмсан гэж боддог” хэмээн хүсэл мөрөөдлөө ярьж байсан.

Гэтэл эсрэгээрээ ямар ч цаг үед өөрийнх нь санаснаар болохгүй бол бухимдан дургүйлхэж, бусдыг үзэн ядаж, өөрийн эрх ашгийн төлөө эв нэгдлийг умартан, нөгөө талаа ялж дийлж л байвал улс, нийгмийн хагаралыг юман чинээ боддоггүй хүн байна. Ялангуяа өнөө үед дэлхий дахинд болж буй үйл явдлуудыг харахаар хүний хувьд чухал зүйлүүд үнэхээр мартагджээ.

Юуны түрүүнд хүмүүс бид олон янзын учрал холбоогоор холбогдон бие биенээ тулж түшиж, бие биенийхээ ачаар амьдардаг гэсэн чухал зүйлийг мартсан байна.

Би дээр үед Америкын сансрын нисгэгч асан Швэикарт гуайн лекцийг сонсож байсан ба тэрээр “Сансар огторгуйг ойлгосон хүн өөрийн эрхгүй тэс өөр хүн болдог” гэж хэлж байсан юм. Үүнийг батлах мэт японы сансрын нисгэгч Ямазаки Наоко сансар огторгуйгаас харсан эх дэлхийн үзэсгэлэн, буцаж ирээд мэдэрсэн сэтгэгдлээ өгүүлэхдээ “Эх дэлхий дээр бүх юмс үзэгдэл харилцан шүтэлцэж, тэнцвэрийг хадгалж, бие биенээ амьдруулж байдаг юм байна. Гэтэл хүмүүс хоорондоо хэрэлдэн тэмцэлдэх нь туйлын харамсалтай. Эх дэлхийг сансраас харах юм бол нэг л бөмбөрцөг дээр бид оршдог” гэж хэлсэн байдаг.

Америкын анхны сансрын нисгэгч Волтэр Ширра (1923-2007) “Би гурван удаа дэлхийгээс гарч байсан боловч надад дэлхийгээс өөр очих



газар байгаагүй. Та бүхнээс эх дэлхийгээ хайрлаж гамнахыг хүсэж байна” хэмээн одоо бидний ухаарч, санаж явах хэрэгтэй чухал зүйлийг онцлон дурдсан. Хүн хүнээ гомдоож, эв нэгдлийг хагалан бутаргах нь хүний ёс, байгаль дэлхийг сүйтгэж, хүн төрөлхтөн өөрөө өөрсдийгөө сөнөөж буйгаас өөрцгүй юм.

Өөрөө гэрэл болж, Номыг дээдлэх нь

Дэлхийн бүх улс төрчид рүү сансраас харагдах дэлхийн зургийг илгээгээд хүний амь нас хэрхэн бий болж, хүн ямар байгалийн хуулийн дагуу амьдардаг болохыг ойлгуулж ухааруулах юм бол “одоо дайн дажин хийх цаг биш” гэж бодох хүн гарч ирэх байх гэж бодогдоно. Эсвэл би их амархан юм бодож байна уу? Ядаж л бурхны сургаал номыг сурч байгаа бид бүхэн эх дэлхийгээ хайрлаж, хэрүүл тэмцэл, хагаралаас хол, эв нэгдлийг эрхэмлэж байгаа нь юутай сайхан бэ.

Хамаг юмс үзэгдэл хувьсан өөрчлөгддөг, бүх зүйл шүтэн барилдлагаар үүсэн бий болж, харилцан хамааралтай байдаг гэсэн орчлонгийн үнэнийг ухаарч, ховор нандин амь насыг хүртсэнээ ойлгох юм бол үзэн ядалт, шуналын гал асахгүй сэтгэл амар амгалан болно (нирваан бол туйлын амгалан) гэж бурхны сургаалд заадаг. Энэ нирвааны туйлын амгаланг Үүсгэн байгуулагч “Хүн хүнээ хайрлаж, энэрч, сул дорой, хүчгүй нэгэндээ гар сунгаж, тусалж туслуулан хамтдаа алхах. Хүн төрөлхтөн ийм байх гэмээнэ амьдрал эрч хүчтэй, утга учиртай, ахиц дэвшилтэй болохын зэрэгцээ амар амгалан байна” гэж дэлгэрэнгүй тайлбарлсан. Ингэж амьдрах юмсан гэсэн өөрийн сэтгэл зүрхээ дагаж (өөрөө гэрэл болж), хорвоогийн жам ёсны хуулийг дагаж (Номыг дээдлэх), зовж шаналж буй хүнд тусалж, мэндийг нь асууж, таньж мэдэхгүй ч гэлээ ядуу зүдүү хүмүүсийн төлөө сэтгэлээ чилээж, чадах зүйлээ хийх нь нирвааны амар амгалан ертөнцийг зорих хүн бүрийн “энх тайвны үйл” юм.

Түүнчлэн Үүсгэн байгуулагч “Өрөөний харанхуйг гайхаж суухынхаа оронд өөрөө хөшгийг нээх хэрэгтэй. Шагжамүни бурхан багшийн сургаал номд суралцаж буй бид бүхэн эхлээд өөрсдөө хүний сэтгэлийг нээцгээе. Мунхагийн харанхуйд бурхны сургаал гэсэн гэрэл гэгээг тусгацгаая” гэж сургасан. Яг одоо энэ үгний утга учир гүнзгий сэтгэгдэл төрүүлж байна.



Сургаалаа шантрахгүй түгээцгээе

Акагава Кэйичи

Та бүгд сайн сууцгааж байна уу?

Цаг хугацаа хурдан өнгөрч 11-р сар гарлаа. Косей кай нийгэмлэгт 12-р сараас шинэ ажлын жил эхэлдэг тул энэ сар сүүлийн сар юм. Нивано ерөнхийлөгч оны эхэнд “Цоо шинэхэн жил” хэмээх айлдвараа түгээж байсан. Та бүхний хувьд энэ жил ямар жил байсан бэ?

Ингээд энэ сард бид “Хагарал ба эв нэгдэл” гэсэн сургаалыг хүлээж авлаа. Өдөр тутмын амьдралаас авхуулаад нийгэм, улс орон, тив дэлхийг харахаар улс орон, бүс нутгийн эрх ашиг, үзэл санаа өөр хоорондоо мөргөлдөж, шийдэл нь олдохгүй дайн дажин, зөрчилдөөн, хагаралын улмаас олон мянган хүн зовж шаналж, нулимс нь хатаж амжаагүй байхад дараагийн зовлон үргэлжилж байна.

Нивано ерөнхийлөгч “Дэлхийн бүх улс төрчдөд хүн хэрхэн байгалийн хуулийн дагуу амьдардаг болохыг ойлгуулж ухааруулах юм бол “одоо дайн дажин хийх цаг биш” гэж бодох хүн гарч ирэх болов уу” хэмээн зөрчил тэмцэл, хагаралаас хол байж, бурхны сургаалын хүчээр энх тайвныг бүтээн байгуулахын чухлыг өгүүлсэн.

Бурхны сургаал түгээж байгаа бид бүхэн “байгалийн хууль” гэдгийг шүтэн барилдлагын хууль, мөнх бусын сургаал, би үгүй гэсэн бурхны сургаалаар хүлээн авч, уулзан учрах хүн бүртэй чин сэтгэлээсээ харилцаж, эв нэгдэл, аз жаргалыг авчрах зам мөрөөр үргэлжлүүлэн алхацгаая.




Акагава дарга 10 сарын 4-ний Үүсгэн байгуулагчийн амин өдрийн ёслолд оролцсон Хавай салбарын гишүүдийн хамт

Rissho Kosei-kai International


Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp